

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Д.Сэр-Од	Дугаар	L189
Оршин суугаа аймаг	Завхан аймаг	Оршин суугаа сум	Шилүүстэй
Төрсөн газар	Шилүүстэй	Төрсөн он	
Ажил мэргэжил	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Наробанчэний хүрээ	Сүм хийдийн дугаар	ГАТШ 116
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 31	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Говь- Алтай аймгийн Тайшир сумын **Наробанчэн** гэгээний хүрээ

Асуулт:-Та бидэнд энэ хүрээний тухай ярьж өгнө үү.?

Хариулт:-**Наробанчэнхутагтийн** сүмийг дээр үеийн түүхтэй ийм олон жилийн түүхтэй юм байна. Энэ нь манай сумын 80 жилийн ойгоор гарсан номон дээр бичигдсэнээр бол урд үеийн байгуулсан сүм, хурал, сургууль, нутаглан суух зэргийг байцааваас анх **Сайшаалт ерөөлтийн** 7 дугаар буюу 1802 онд **Наробанчэнхутагт** Агваан **Чойрданзанжамц** дээдийн түмэн өлзий хутагтад ном уншуулахаар Завхан голын **хойтох** Чандмань уулын өвөрт сүм хийд байгуулж айлтгасан нь зарлигаар **солжидийг** бадруулагч сүм хэмээн нэрлэжээ гэж. Мөн онд Цогчэн, **Хангал, Ганжуур**, хайлан хурлуудыг хурж, **Майдар бурханы** дээд түмэн өлзий бататгахын хурал өдөр бүр хурж тогтоожээ. Буйан засагчийн 3 дугаар буюу 1864 онд тус шавийн **Дилав** хутагт **Эрхцорж рашпунцаг цанид** хурал хуруулахаар бүсэнд нь уламжилж дээрхийн гэгээний Богд **Жавзандамба** хутагтад айлгасанд **Жамъянчадавын игчаагаар Цанидын** дацан байгуулж мөн хурлыг тогтоож болно хэмээжээ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Бадаргуулт төрийн 6 дугаар буюу 1880 онд **Наробанчэн** хутагт Бирваа, мөн шавийн хутагт Шавийн **Дилав** хутагт **Эрхцорж Рашпунцаг** нар **Жүдийн** дацан байгуулж ном хурлыг хуруулж тогтоожээ. Олноо өргөгдсөний 8 дугаар буюу 1918 онд энэхүү хоёр дацанд нэр гуйж өргөмжлөн айлтгасанд Очир дарь эзэн гэгээний зарлигаар **Цанид** дацанд Чоён **жирмэд дэчинлэн**, жүд дацанд дэвшин сүмбэрлэн хэмээн тус тус нэр шагнасныг хичээнгүйлэн дагаж хэвээр хурал ном хуруулж **бүхүйгээс** гадна 4 улирал дараалан **одон цанчид, найдан чого**, Манал, **Нүгнээ** эдгээр хурлуудыг хурж **Ламиран, ложин, цанид** эдгээр номын сургуулийг үүсгэжээ.

Наробанчэн хутагт, Дилав хутагт нар суух газар Завхан голын зах, Чандмань уулын өвөрт хийдийн дэргэд суудаг болно. Үүнээс хойш энэ хоёр ламын байгуулсан сүм, дацан 3, хурал 18, суусан газар 1 болой гэхчлэн тодорхойлсон мэдүүлсэн байна. **Наробанчэн хутагтийн** шавийн хүрээ бол дэлхийн шарын шашны хоёр томоохон төлөөлөгч болон **Нарванчин, Дилав** хутагт нарын хувилгаан дүрүүд үе **үеээрээ** залран сууж байсан түүхтэй. Очирваанийн **орны** ариун дагшин өлгий юмаа.

Энэ хүрээ нь сүм **дуганын** хийц зохиомж, дээврийг гангийн чиглэлээр хосгүй чамин хийцтэйгээрээ олон сүм хийдийн дундаас нэртэй байсан гэдэг юм. Барааны газраас алтан **ганжир** нь туяа мэт шаргалтаж, түмэн зул асаасан мэт яралзан тунарч харагдах нь аргагүй л халхын хоёр том гэгээний ид **шидэнд** бишрэх, жир хүмүүсийн сэтгэлийг улам ариусган цэлмүүлдэг бөлгөө. Андуу гэгээн Бирваа жүдийн **дацанг** хятадуудаар бариулаад бэлэн мөнгө, сайхан барь гэхэд зарим шавь нар нь энэ мангарт мөнгө байхгүй, энэ их мөнгийг хаанаас олох юм бэ гэж байсан. Дуганаа бариулж дуусаад шавь ардуудыг явуулж хойт **Цахирын** цагаан чулуунаас авчруулан цэгнэж өгөхөд мөнгө болсон байна гэнээ. Энэ үед андуу дүрийн хувилгааны ид **шидэнд** бишрэгч манай мангар чинь тэр аяараа лусын сантай юм гэгцгээж байсан гэдэг.

Ар монголд Манжийн засгаас Автономитын үе хүртэл 13-хан тамгатай хутагт байсны 2 нь нэгэн хүрээнд зэрэгцэн сууж байсан нь **ховорхон** тохиох учрал бөгөөд энэ хоёр **хутагтын** хүрээнд эргэл мөргөлөөр ирэх хүмүүс цагаачлан амьдрах нь элбэг байснаас уг шавийн нутагт олон газраас торгууд, өөлд, дөрвөд зэрэг янз бүрийн ястан үндэстэн суурьшин амьдарсан байдаг. Энэ хүрээнд **Наробанчэн хутагтын** монголд тодорсон сүүлчийн 5 дүрүүд, **Дилав хутагтын** сүүлчийн 3 дүр залагдан сууж түмэн шавь нартаа бүян хишгээ хайрласаар байсан түүхтэй юм байна.

Асуулт:-Энэ хүрээ сүүлд хэдэн оны орчим байхгүй болсон юм бол? Хэлмэгдэлд өртөж байхгүй болсон юм бол, лам нарыг нь яасан юм бол?

Хариулт:-**Дилав** хутагт Жамсранжавыг 1929 онд хүрээнээс нь барьж машинаар хотод авчирсан байгаа юм. Тэрнээс хойш ер нь 30-аад оны үед л хэлмэгдүүлэлтийн үед л устаж үгүй болсон байх. Яг албан ёсны тэдэнд онд яасан гэсэн тийм мэдэгдэх юм байдаггүй. Үлдэж бичсэн юм байхгүй юм байна лээ.

Асуулт:-Өөр танд энэ хийдийн талаар мэдэх юм байна уу? Ганжуур, **Данжуур** гэж судар байсан уу?

Хариулт:-Энд өдөр болгон тогтмол ном хурдаг учраас хурахгүй ном гэж байдаггүй юм байсан.

Асуулт:-Цам, **Майдар** гардаг байсан уу?

Хариулт:-Тэрнийг би үнэхээр сайн мэдэхгүй юм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Ямар уул овоогоо тахидаг байсан юм бол?

Хариулт:-Гэгээн овоо гэж манай сүманд байдаг тэрнийг хавар болгон тахидаг, тэгээд **Майдар** эргэдэг ийм байсан гэж энэ номонд бичсэн байна.

Асуулт:-Яаж тахидаг байсан юм бол, цагаан идээгээр үү, шүүсээр тахидаг байсан үү? наадам хийдэг байсан үү?

Хариулт:-Тэр нарийн юм ёстой мэдэхгүй.

Асуулт:-Ер нь ингээд өөр мэдэх юм байна уу?

Хариулт:-Өөр мэдэх юм алга, энэ дээр **байгаагий** нь би бараг үншаад шахуу хэлээд өгчихлөө шүү дээ.